



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Нямтайширын НОМТОЙБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-22-87, Факс: 32-70-16
E-mail: nomtoibayar@parliament.mn
http://www.parliament.mn

2016. 11. 21 № 13052

танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар дугаар зүйлийн нэг дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбоотой үүссэн асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах чиг үүрэг бүхий "Түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулж, өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

Хавсралт 4 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.НОМТОЙБАЯР

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Д.ГАНБОЛД

О.СОДБИЛЭГ

А.УНДРАА

Д.ОЮУНХОРОЛ

Н.АМАРЗАЯА



О.БААСАНХҮҮ



Б.ПҮРЭВДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Нямтайширын НОМТОЙБАЯР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-22-87, Факс: 32-70-16
E-mail: nomloibayar@parliament.mn
http://www.parliament.mn

2018. 11-19 № 1297Б

танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбоотой үүссэн асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог байгуулах нь зүйтэй гэж үзэж "Түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

Хавсралт 4 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.НОМТОЙБАЯР





ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь улс орны эдийн засгийн бодит салбарын үйл ажиллагааг дэмжиж, импортыг орлох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр шинээр бий болгох, Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэд аж ахуй эрхлэх, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших эрхээ хэрэгжүүлэх баталгаа болж байдаг билээ.

Гэтэл Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Улсын Их Хурал, Засгийн газрын нэр бүхий гишүүд, төрийн зарим өндөр албан тушаалтан албаны эрх нөлөөгөө ашиглан өөрийн болон хамаарал бүхий этгээдийнхээ компанид зээл авч өгсөн, зуучилж нэр холбогдсон ноцтой асуудал гарлаа.

Нийгмийн зорилтот бүлэг, тэр дундаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр олгодог зээлээс Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд болон төрийн өндөр албан тушаалтны өөрийн болон хамаарал бүхий компанидаа зээл авсан асуудалд иргэд, олон нийт илтэд шүүмжлэлтэй хандаж, хариуцлага, ёс зүй, шударга ёсыг та биднээс шаардаж байна.

Улсын Их Хурал түүнийг бүрдүүлж байгаа гишүүд ард түмний элч, нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж, аливаа хууль бус үйлдэл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх учиртай бөгөөд иргэд, олон нийт, аж ахуй эрхлэгчдийн шаардлагыг хүлээн авч, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбогдсон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, төрийн өндөр албан тушаалтанд ёс зүйн болон хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүйд нийцнэ.

Засгийн газар буюу Сангийн яамнаас ажлын хэсэг гаргаж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Засгийн газрын бусад сангийн үйл ажиллагааг шалгаж байгаа нь илт ашиг сонирхлын зөрчилтэй. Засгийн газрын гишүүд өөрсдөө уг асуудалд холбогдсон, эрх нөлөө бүхий төрийн өндөр албан тушаалтан албаны эрх мэдэл, нөлөөгөө ашиглан шалгалтын үр дүн сөргөөр нөлөөлөх бодит үндэслэл байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт "Тодорхой асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллуулж болно" гэж заасныг үндэслэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбоотой үүссэн асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог байгуулах тогтоолын төсөл боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 3 заалттай байх бөгөөд нэгд нь түр хорооны үндсэн чиг үүргийг тодорхойлон байгуулах, хоёрт нь эрхлэх асуудлынхаа хүрээнд Тусгай хяналтын дэд хороо түр хороонд дэмжлэг үзүүлэн ажиллах, гуравт нь тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтоох болно.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэд аж ахуй эрхлэх, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших эрхээ хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх, нийгмийн зорилтот бүлэг, тэр дундаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр олгодог зээлээс өөрийн болон хамаарал бүхий компанидаа зээл авсан асуудалд холбогдсон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд болон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх боломжийг бүрдүүлнэ.

Мөн иргэд, олон нийтээс тавьж буй шаардлага биелнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, цаашид шинээр боловсруулах нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хуультай нийцэж байгаа бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

Төсөл санаачлагчид

ТАНИЛЦУУЛГА

“Түр хороо байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Нийгмийн зорилтот бүлэг, тэр дундаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр олгодог зээлээс Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд болон төрийн өндөр албан тушаалтны өөрийн болон хамаарал бүхий компанидаа зээл авсан асуудал тодорхой баримт нотолгоотой олон нийтэд хүрээд багагүй хугацаа өнгөрсөн.

Гэтэл энэ асуудлын хүрээнд Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн төдийхнөөр хариуцлагын асуудал хязгаарлагдсан. Засгийн газар тэр дундаа Сангийн яамнаас ажлын хэсэг гарган Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон Засгийн газрын бусад сангийн үйл ажиллагааг шалгаж байгаа гэх боловч тодорхой үр дүн гараагүй. Ёс зүйн болон хуулийн хариуцлага хүлээж байгаа албан тушаалтан байхгүй байна. Үүнд иргэд, олон нийт илтэд шүүмжлэлтэй хандаж, буруутай этгээдэд ёс зүйн болон хуулийн хариуцлага хүлээлгэхийг төрөөс шаардаж байна.

Түүнчлэн асуудалд холбогдсон Засгийн газар өөрийгөө шалгаж байгаа, эрх мэдэл бүхий төрийн өндөр албан тушаалтан уг асуудалд холбогдсон зэрэг нь шалгалтын үр дүнд сөргөөр нөлөөлж, үнэн зөв, бодит мэдээлэл гарна гэдэгт иргэд, олон нийт итгэхгүй байна.

Иймд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд бид Улсын Их Хурлаас хараат бус, бие даасан байдлаар ажиллах түр хороог байгуулж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбоотой үүссэн асуудлыг хянан шалгах нь зүйтэй гэж үзэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Түр хороо байгуулах тухай тогтоолын төсөл боловсруулав.

Тогтоолын төсөл нь түр хорооны үндсэн чиг үүргийг тодорхойлон байгуулах, эрхлэх асуудлынхаа хүрээнд Тусгай хяналтын дэд хороо түр хороонд дэмжлэг үзүүлэн ажиллах, тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөх гэсэн 3 заалттай болно.

Төсөл санаачлагчид

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай холбоотой үүссэн асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

1/Нямтайширын Номтойбаяр	Улсын Их Хурлын гишүүн
2/Бөхчулуун Пүрэвдорж	Улсын Их Хурлын гишүүн
3/Жадамбын Бат-Эрдэнэ	Улсын Их Хурлын гишүүн
4/Даваагийн Ганболд	Улсын Их Хурлын гишүүн
5/Отгонбилэгийн Содбилэг	Улсын Их Хурлын гишүүн
6/Агваанлуvsангийн Ундраа	Улсын Их Хурлын гишүүн
7/Дуламсүрэн Оюунхорол	Улсын Их Хурлын гишүүн
8/Бөхчулуун Пүрэвдорж	Улсын Их Хурлын гишүүн
9/Октябрийн Баасанхүү	Улсын Их Хурлын гишүүн

2.Эрхлэх асуудлын хүрээнд түр хороонд дэмжлэг үзүүлэн ажиллахыг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороонд даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг